- 41.3. ТШЗ-ны 39.1-д гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг шаардсан тохиолдолд хуулийн 44.3-т заасны дагуу урьдчилгаа төлбөрийн баталгааны дүнд гүйцэтгэлийн баталгааны дүнг оруулан тооцож болно.
- 41.4. Урьдчилгаа төлбөрийн баталгаа нь ТШЗ-ны 7.5-д заасан загварын дагуу байх ба гадаадын этгээдээс гаргуулах бол ТШЗ-ны 22.4-т заасан шаардлагыг хангасан байна.
- 41.5. Захиалагчийн хүлээн авсан, шаардлага хангасан урьдчилгаа төлбөрийн баталгаа нь гэрээний салшгүй хэсэг байна.
42. **Тендер шалгаруулалттай холбоотой гомдол**
- 42.1. Тендерт оролцогч тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг хууль тогтоомжийн дагуу гаргана.

43. Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулах тендер шалгаруулалт

- 43.1. ТШЗ-ны 1.1-д заасан тендер шалгаруулалтыг урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулж байгаа үед энэ тухай ТӨХ болон тендерийн урилгад заана.
- 43.2. Захиалагч ТШЗ-ны 43.1-д заасны дагуу зохион байгуулах тендер шалгаруулалтад энэ тендерийн баримт бичгээс гадна “Урьдчилсан худалдан авах ажиллагааны журам”-д заасан нөхцөлийг мөрдөнө.
- 43.3. Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулах тендер шалгаруулалтаар тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр бүрэн батлагдах хүртэл гэрээ байгуулахгүй.
- 43.4. Санхүүжилтийн эх үүсвэр батлагдаагүй, эсхүл цар хүрээ, хүчин чадлыг өөрчилж, төсөвт өртгийг ТШЗ-ны 2.1-д зааснаас өөрөөр баталсан бол урьдчилсан худалдан авах ажиллагааг хэрэгжих боломжгүй болсон гэж үзэж гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгоно.
- 43.5. ТШЗ-ны 43.4-т зааснаар гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгосонтой холбоотой аливаа эрсдэлийг тендерт оролцогч хариуцна.

44. Тендер шалгаруулалтын мэдээллийг нийтлэх

- 44.1. Тендер шалгаруулалтын мэдээллийг хууль тогтоомжид заасны дагуу цахим системд нийтэлж, ил болгоно.
- 44.2. Захиалагч нээлтийн тэмдэглэл, тендер шалгаруулалтын үр дүнг цахим системд олон нийтэд ил тод мэдээлнэ.

--oOo--

II БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ТӨХ)

Санамж

Захиалагч гүйцэтгүүлэх ажлын онцлог шинж, тендерт оролцогчид тавигдах холбогдох хууль тогтоомж, түүний зарчимд нийцсэн шаардлага, шалгуур үзүүлэлтийг тендерийн өгөгдлийн хүснэгтэд тусгана.

Тендерийн өгөгдлийн хүснэгтийг боловсруулахад дараах зүйлийг анхаарна. Үүнд:

1. ТӨХ нь ТШЗ-ны зүйл, заалт болон түүнд хамаарах хэсгийг налуугаар бичсэн зааварт нийцүүлэн тохирох мэдээллийг нөхөх, гүйцээх зорилготой ба ТӨХ-д мөр нэмэхгүй, хасахгүй байх;
2. Тендерт оролцогчийн санхүүгийн болон техникийн чадавх, туршлагад тавих шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаж буйг тогтоох зорилгоор шаардах баримт бичиг нь зөвхөн тендерт оролцогчийг тухайн ажил гүйцэтгэх гэрээний үүргийг гүйцэтгэх чадавх, туршлагатай болохыг нотлох баримт бичиг байна;
3. ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан баримт бичгүүдээс аль тохирох баримт бичгийг сонгож ТӨХ-д тусгайлан заана;
4. Тендерт оролцогч өөрийн тендерийн үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна. Иймд захиалагч хуулиар шаардсанаас бусад тохиолдолд тендерт хавсарган ирүүлэх баримт бичгийг нотариатаар гэрчлүүлэх, орчуулагчийн тэмдгээр баталгаажуулахыг тендерт оролцогчоос шаардахгүй;
5. Худалдан авах ажиллагааны цахим системтэй холбогдсон бусад мэдээллийн сангаас илгээсэн өгөгдлийг нотлох баримт бичгийг тендерт ирүүлэхийг шаардахгүй байх. Тухайлбал, Монгол Улсын хуулийн этгээдэд хамаарах улсын бүртгэлийн гэрчилгээ, тендерийн баталгаа, авто тээврийн хэрэгслийн эзэмшигчийн лавлагаа, санхүүгийн тайлан, татварын тодорхойлолт гэх мэт болно.

Энэхүү санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

II БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ТӨХ)

ТШЗ-ны заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: Нэмэлт тодотгол ТЭЗҮ
ТШЗ 1.1	Тендерийн урилгын дугаар: ДААТҮТӨХК/2023042320
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Өөрийн хөрөнгө
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 180,000,000 / Нэг зуун наян сая / төгрөг
ТШЗ 5.1	Тендерт оролцогч нэг ба түүнээс дээш тооны этгээдтэй туслан гүйцэтгүүлэх гэрээ байгуулж болно. Нийт туслан гүйцэтгүүлж болох бараа, ажил, үйлчилгээний дээд хэмжээ нь тендерийн үнийн 10 хувиас хэтрэхгүй байна.
ТШЗ 5.2	Түншлэлийн гишүүд дараах нэмэлт шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд: (а) Түншлэлийн гэрээ нь Иргэний хуульд заасан хамтран ажиллах гэрээний шаардлага хангасан байна. (б) Түншлэлийн гэрээнд түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн болон түншлэлийн гишүүдийг тодорхойлж, түншлэлийн гишүүд тус бүрийн гүйцэтгэх ажил, үнийн дүн, хувийг тодорхой тусгасан байна. (в) Түншлэлийн аль нэг болон бүх гишүүний нэрийн өмнөөс үүрэг хүлээх, зааварчилгаа хүлээн авах, төлбөр тооцоо хийхэд тэдгээрийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүн томилох; (г) Нийт гэрээний гүйцэтгэл, түүний дотор төлбөрийг зөвхөн төлөөлөх эрх бүхий гишүүнтэй тооцохыг хамтран ажиллах гэрээгээр зохицуулсан байх; (д) Түншлэлийн гэрээний хувийг тендерийн хамт ирүүлэх. (е) Түншлэлийн гишүүн бүр энэхүү ТӨХ-д заасан бүх мэдээллийг тус бүрдээ гаргаж, тендерийн хамт ирүүлнэ. Тендерт оролцогч түншлэлийн хувьд 18.2 ба 18.2.5-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмнэ. Гэхдээ гишүүн тус бүр 18.2 ба 18.2.5-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийн доод тал нь 25 хувийг, төлөөлөх эрх бүхий гишүүн доод тал нь 40 хувийг хангасан байх ёстой. Дээрх шаардлагыг түншлэлийн гэрээнд тусгаагүй тохиолдолд түншлэлийг шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана. Анхааруулга: Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журмын 3.3.1-д “Тендерт оролцогч нь түншлэлээр оролцох бол талууд цахим системээр дамжуулан гэрээ байгуулсан байх;” гэж заасны дагуу цахим системээр дамжуулан гэрээ байгуулаагүй тохиолдолд уг журмын 3.11-д “Тендерт оролцогч тендер илгээхдээ журмын 3.3.1-д зааснаар түншлэлийн бусад гишүүдтэй гэрээ байгуулаагүй бол хуулийн 5.1.6.б-д заасан тендерт оролцогч гэж үзэхгүй” гэж заасны дагуу түншлэлээр тендерт оролцсон гэж үзэхгүй болохыг анхаарна уу.
Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА	
ТШЗ 8.2	Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг: Хүлээн авагчийн нэр: “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК Хаяг: Дархан-Уул аймаг, Дархан сум, 16-р баг, өөрийн байр, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК Утасны дугаар: 7509-0044

	Цахим шуудангийн хаяг: www.tender.gov.mn төрийн худалдан авах ажиллагааны цахим систем Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5-аас доошгүй хоног байна. Тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийн хариуг хүсэлт гаргагчийн нэрийг дурдалгүйгээр Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д нийтлэх бөгөөд тус тодруулга, нэмэлт мэдээллийг бүх тендерт оролцогчдод нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно. Иймд тендерт оролцохыг сонирхогч этгээдүүд цахим систем дэх тендерийн урилгын тодруулга, мэдээллийг байнга шалгахыг зөвлөж байна.
ТШЗ 9.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “Үгүй”
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.2	Тендер шалгаруулалтын хэл: Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, тендерт оролцогчдын ирүүлэх тендер “Монгол хэл”-ээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг заавал баталгаат орчуулгын хамт “Монгол хэл”-ээр ирүүлнэ.
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: “Зөвшөөрөхгүй”
ТШЗ 16.1	Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, шимтгэл, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн, өр төлбөргүй байх шаардлагатай. Татварын тодорхойлолтыг ирүүлэх шаардлагагүй, “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” www.tender.gov.mn болон “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас шалгана. Санамж: Тендерт оролцогчийн ирүүлсэн татварын тодорхойлолтыг үнэлгээнд харгалзан үзэхгүй.
ТШЗ 16.2.1	Шүүхийн төрөлжсөн архивын лавлагаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг цахим хэлбэрээр авна. Тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлт хийхээс 3-аас доошгүй хоногийн өмнө нэвтрэн орж шүүхийн тусгай архивын лавлагаа авах хүсэлтийг илгээх бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл хянан үзэж лавлагаа цахимаар илгээдэг болохыг анхаарна уу. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт авах хүсэлтийг тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлтээс өмнө хүчин төгөлдөр тодорхойлолтыг цахим хэлбэрээр ирүүлнэ. Жич: Дээрх 2 лавлагаа авах зааварчилгаатай www.tender.gov.mn цахим системийн хэрэглэгчийн хөтөч чэсээс танилцана уу. Санамж: Хэрэв дээрх тодорхойлолтуудыг цахимаар ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.
ТШЗ 17.2	Тендерт оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага: Борлуулалтын орлогын хэмжээ: 2021, 2022 онуудын борлуулалтын орлогын нийлбэр нь батлагдсан төсөвт өртөгийн 80 хувиас багагүй байна.
ТШЗ 17.2.1	Монгол банкны лавлагааг авч, баталгаажуулж ирүүлнэ. Хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэхийг хянан үзнэ.
ТШЗ 17.2.5	Санхүүгийн чадавхын талаар энэ зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангах бусад баримт: “Шаардана” Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: Санал болгож буй үнийн дүнгийн 80 хувиас багагүй байна.

	<p>Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээ нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Байгууллагын дансны үлдэгдэл /Харилцагч банкны/; - Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт ирүүлнэ; - Тайлант үеийн түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ; - Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд; 																																								
ТШЗ 17.3	Тендерт оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2021, 2022 онуудын санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.ebalance.mof.gov.mn мэдээллийн системээс тендерт оролцогчдын санхүүгийн тайлангаас сүүлийн 2 жилийн борлуулалтын орлого, болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана.																																								
ТШЗ 17.6.1	Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: “Шаардана”																																								
ТШЗ 17.6.2	Ажил гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн мэдээлэл: “Шаардана”																																								
	<table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Албан тушаал</th> <th>Тоо</th> <th>Ажлын туршлага</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Төслийн удирдагч</td> <td>1</td> <td>10-аас доошгүй жил уул уурхайн үйлдвэрлэл, үйл ажилгааны чиглэлээр шинжилгээ, зураг төсөл, ТЭЗҮ боловсруулж байсан туршлагатай. Уул уурхайн чиглэлээр мэргэшсэн инженер түүнээс дээш зэрэгтэй байх ба компанийн үндсэн ажилтан байна.</td> </tr> <tr> <td>2</td> <td>МУ-ын зөвлөх инженер</td> <td>2</td> <td>20-оос доошгүй жилийн туршлагатай. Уул уурхайн чиглэлээр МУ-ын зөвлөх инженер зэрэгтэй байна.</td> </tr> <tr> <td>3</td> <td>Зураг төслийн ерөнхий инженер</td> <td>1</td> <td>10-аас дээшгүй жилийн туршлагатай. Уул уурхайн чиглэлээр МУ-ын мэргэшсэн инженер зэрэгтэй байна.</td> </tr> <tr> <td>4</td> <td>Зураг төслийн инженер</td> <td>3</td> <td>3-аас дээшгүй жилийн туршлагатай. Уул уурхайн ашиглалтын инженер зэрэгтэй байна.</td> </tr> <tr> <td>5</td> <td>Геологич инженер</td> <td>1</td> <td>10-аас доошгүй жилийн ажлын туршлагатай байна.</td> </tr> <tr> <td>6</td> <td>Баяжуулалтын инженер</td> <td>2</td> <td>Ашигт малтмалын баяжуулалтын технологи мэргэжилтэй байна.</td> </tr> <tr> <td>7</td> <td>Гидрогеологич</td> <td>1</td> <td>3-аас доошгүй жилийн туршлагатай байна. Гидрогеологич мэргэжилтэй байна.</td> </tr> <tr> <td>8</td> <td>Эдийн засагч</td> <td>1</td> <td>Төслийн болон ТЭЗҮ-ийн хөрөнгө оруулалт, эдийн засгийн үнэлгээ, эрсдэлийн шинжилгээний чиглэлээр ажиллаж байсан туршлагатай байна.</td> </tr> <tr> <td>9</td> <td>Бусад</td> <td></td> <td>Гадаад улсын эксперт ажиллах тохиолдолд тухайн ажилтнууд нь уул уурхайн үйлдвэрлэл, үйл ажиллагааны чиглэлээр судалгаа шинжилгээ, зураг төсөл боловсруулж байсан туршлагатай байна.</td> </tr> </tbody> </table>	№	Албан тушаал	Тоо	Ажлын туршлага	1	Төслийн удирдагч	1	10-аас доошгүй жил уул уурхайн үйлдвэрлэл, үйл ажилгааны чиглэлээр шинжилгээ, зураг төсөл, ТЭЗҮ боловсруулж байсан туршлагатай. Уул уурхайн чиглэлээр мэргэшсэн инженер түүнээс дээш зэрэгтэй байх ба компанийн үндсэн ажилтан байна.	2	МУ-ын зөвлөх инженер	2	20-оос доошгүй жилийн туршлагатай. Уул уурхайн чиглэлээр МУ-ын зөвлөх инженер зэрэгтэй байна.	3	Зураг төслийн ерөнхий инженер	1	10-аас дээшгүй жилийн туршлагатай. Уул уурхайн чиглэлээр МУ-ын мэргэшсэн инженер зэрэгтэй байна.	4	Зураг төслийн инженер	3	3-аас дээшгүй жилийн туршлагатай. Уул уурхайн ашиглалтын инженер зэрэгтэй байна.	5	Геологич инженер	1	10-аас доошгүй жилийн ажлын туршлагатай байна.	6	Баяжуулалтын инженер	2	Ашигт малтмалын баяжуулалтын технологи мэргэжилтэй байна.	7	Гидрогеологич	1	3-аас доошгүй жилийн туршлагатай байна. Гидрогеологич мэргэжилтэй байна.	8	Эдийн засагч	1	Төслийн болон ТЭЗҮ-ийн хөрөнгө оруулалт, эдийн засгийн үнэлгээ, эрсдэлийн шинжилгээний чиглэлээр ажиллаж байсан туршлагатай байна.	9	Бусад		Гадаад улсын эксперт ажиллах тохиолдолд тухайн ажилтнууд нь уул уурхайн үйлдвэрлэл, үйл ажиллагааны чиглэлээр судалгаа шинжилгээ, зураг төсөл боловсруулж байсан туршлагатай байна.
№	Албан тушаал	Тоо	Ажлын туршлага																																						
1	Төслийн удирдагч	1	10-аас доошгүй жил уул уурхайн үйлдвэрлэл, үйл ажилгааны чиглэлээр шинжилгээ, зураг төсөл, ТЭЗҮ боловсруулж байсан туршлагатай. Уул уурхайн чиглэлээр мэргэшсэн инженер түүнээс дээш зэрэгтэй байх ба компанийн үндсэн ажилтан байна.																																						
2	МУ-ын зөвлөх инженер	2	20-оос доошгүй жилийн туршлагатай. Уул уурхайн чиглэлээр МУ-ын зөвлөх инженер зэрэгтэй байна.																																						
3	Зураг төслийн ерөнхий инженер	1	10-аас дээшгүй жилийн туршлагатай. Уул уурхайн чиглэлээр МУ-ын мэргэшсэн инженер зэрэгтэй байна.																																						
4	Зураг төслийн инженер	3	3-аас дээшгүй жилийн туршлагатай. Уул уурхайн ашиглалтын инженер зэрэгтэй байна.																																						
5	Геологич инженер	1	10-аас доошгүй жилийн ажлын туршлагатай байна.																																						
6	Баяжуулалтын инженер	2	Ашигт малтмалын баяжуулалтын технологи мэргэжилтэй байна.																																						
7	Гидрогеологич	1	3-аас доошгүй жилийн туршлагатай байна. Гидрогеологич мэргэжилтэй байна.																																						
8	Эдийн засагч	1	Төслийн болон ТЭЗҮ-ийн хөрөнгө оруулалт, эдийн засгийн үнэлгээ, эрсдэлийн шинжилгээний чиглэлээр ажиллаж байсан туршлагатай байна.																																						
9	Бусад		Гадаад улсын эксперт ажиллах тохиолдолд тухайн ажилтнууд нь уул уурхайн үйлдвэрлэл, үйл ажиллагааны чиглэлээр судалгаа шинжилгээ, зураг төсөл боловсруулж байсан туршлагатай байна.																																						
ТШЗ 17.6.3	Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, программ хангамж: “Шаардана”																																								
ТШЗ 17.6.4	Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл: “Шаардлагатай” Ижил төстэй гэрээний туршлага: 2021, 2022 онуудад ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний үнийн дүнгийн нийлбэр нь төсөвт өртгийн 60 хувиас багагүй байх бөгөөд доод тал нь нэг удаа ижил төстэй ажил гүйцэтгэсэн байх шаардлагатай.																																								

	Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/																		
ТШЗ 17.6.5	<p>Ижил төстэй ажил гүйцэтгэж байсан туршлагыг /Маягт-6/, ажил гүйцэтгэсэн гэрээ, гэрээ дүгнэсэн акт, протокол эсхүл дүгнэлт ирүүлнэ. Санамж: Хүснэгтээр санал болгосон ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын гэрээ, гэрээ дүгнэсэн акт, протокол эсхүл дүгнэлтийн аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд туршлагын мэдээлэлд тооцохгүй үнийн дүнгээс хасахыг анхаарна уу.</p> <p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад баримт: “Шаардана.”</p> <ol style="list-style-type: none"> Тендерт оролцогчийн ирүүлсэн тендерийн баримт бичиг, саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг ирүүлнэ. Компанийн танилцуулга Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан ажлын даалгаврын дагуу чанарын шаардлага хангасан ажлыг гүйцэтгэх тухай албан бичиг ирүүлнэ. Ажлын даалгаврыг баталгаажуулан ирүүлнэ. <p>Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод байх шаардлагатай бөгөөд уншигдахгүй материалыг ирүүлээгүйд тооцно. ТӨХ-д шаардсан материалуудын аль нэг ирүүлээгүй, эсхүл өөрөөр ирүүлсэн тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</p>																					
ТШЗ 17.7.	<p>Тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: “Шаардана”.</p> <table border="1" data-bbox="456 1249 1490 1554"> <thead> <tr> <th data-bbox="456 1249 590 1451">Гэрээний нэр</th> <th data-bbox="596 1249 785 1451">Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас</th> <th data-bbox="791 1249 925 1451">Төсөвт өртөг</th> <th data-bbox="932 1249 1091 1451">Гэрээ эхэлсэн хугацаа</th> <th data-bbox="1098 1249 1279 1451">Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр</th> <th data-bbox="1286 1249 1490 1451">Дуусах хугацаа</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="456 1460 590 1494"></td> <td data-bbox="596 1460 785 1494"></td> <td data-bbox="791 1460 925 1494"></td> <td data-bbox="932 1460 1091 1494"></td> <td data-bbox="1098 1460 1279 1494"></td> <td data-bbox="1286 1460 1490 1494"></td> </tr> <tr> <td data-bbox="456 1503 590 1536"></td> <td data-bbox="596 1503 785 1536"></td> <td data-bbox="791 1503 925 1536"></td> <td data-bbox="932 1503 1091 1536"></td> <td data-bbox="1098 1503 1279 1536"></td> <td data-bbox="1286 1503 1490 1536"></td> </tr> </tbody> </table> <p>Санамж: Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээллийг www.tender.gov.mn цахим системээс хянан үзнэ.</p>				Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа												
Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа																	
ТШЗ 19.5.	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулахгүй тогтмол байна”																					
ТШЗ 21.1	Тендерийн хүчинтэй хугацаа: Тендер нээснээс хойш “30” хоногийн туршид хүчинтэй байна.																					
ТШЗ 22.1	<p>Тендерийн баталгаа: “Шаардана” Тендерийн баталгааны үнийн дүн: 900,000 /есөн зуун мянган / төгрөг байна. Хүчинтэй байх хугацаа: Тендер нээснээс хойш 58 хоног түүнээс дээш байна.</p> <p>Цахим тендерт оролцогч тендерийн материалд цахим тендерийн баталгааг хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим систем цахим тендерийн баталгаа гаргагч арилжааны</p>																					

	банкны мэдээллийн сангаас тендерт оролцогчийн цахим тендерийн баталгааны талаарх мэдээллийг шалгана. Баталгааг цахимаар ирүүлээгүй нь тендерээс татгалзах шалтгаан болно.
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 23.5.3	ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан болон V бүлгийн маягуудаас гадна бусад тендерт оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: Тендерт оролцогч нь Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь файл үүсгэн ирүүлнэ. Тус файлын эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн эрх бүхий этгээд баталгаажуулан ирүүлнэ.
ТШЗ 24.1.	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Цаг: 10 цаг 00 минут
ТШЗ 26.1.	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг тендерт оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Цаг: 10 цаг 10 минут
Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ	
ТШЗ 30.2	Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: “Ашиглахгүй”
Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	
ТШЗ 39.1	Шалгарсан тендерт оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: “Тийм” Тендерт шалгарсан оролцогч нь гэрээний үнийн дүнгийн 3%-тай тэнцэх хэмжээний гүйцэтгэлийн баталгаа гаргана.
Ё. БУСАД	
ТШЗ 41.1	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: “Үгүй”
ТШЗ 43.1	Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдаж байгаа эсэх: “Үгүй”

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Техникийн тодорхойлолт бэлтгэх санамж

[Захиалагч болон үнэлгээний хороо нь ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд захиалагчийн зураг төсөл (техникийн болон ажлын зураг, өртгийн төсөв), ажлын хуваарь, тоног төхөөрөмж нийлүүлж, суурилуулан, уг барилга байгууламжийг ашиглалтад бэлэн болгохтой холбоотой ажил, бараа, үйлчилгээнд тавигдах шаардлага, техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай ажил болон тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах бараа, үйлчилгээг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендерт оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.*
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.*
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөвт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.*
- Тендерийн баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана.*
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.*
- Бараа материалын техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.*
- Ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтын хувьд санал болгох бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.*

Зураг төсөл, загвар зураг

Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтад ажлын зураг, өртгийн төсвийг хавсаргана. Ажлын зураг, өртгийн төсвийг тухайн салбарын дүрэм, журмыг үндэслэн боловсруулж холбогдох зардлын хувь хэмжээг нарийвчлан заасан байна.

Шалгалт, туршилт

Захиалагч тендерт оролцогчоос тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгатай холбоотой зааварчилгаа, мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.

Тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгыг хэрхэн шалгах, турших тухай тодорхой заана.

Үе шатны ажлын хуваарь

Ажлын гүйцэтгэлийг хянаж шалгахад үе шатны ажлын хуваарийг ашиглана.]

[Үнэлгээний хороо худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д нийтэлсэн нэг маягийн загвар зураг, техникийн тодорхойлолтын жишиг нөхцөл, стандартыг баримтлан тендерийн баримт бичгийг боловсруулна.]

**БАТЛАВ. УУЛ УУРХАЙ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОДЛОГЫН
ГАЗРЫН ДАРГА**



Н.БАТБАЯР

**ТӨМӨРТЭЙ MV-013319 УУРХАЙН ЗҮҮН ХЭСГИЙГ АШИГЛАХ
ТЭЗҮ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2023.09.14

Д/д	ҮЗҮҮЛЭЛТ	ТАЙЛБАР
1	Ордын нэр	Төмөртэйн уурхай
2	Ордын байршил	Сэлэнгэ аймгийн Хүдэр сум
3	Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-013319
4	Ажлын зорилго, гарах үр дүн:	Төмөртэй төмрийн хүдрийн ордыг эдийн засгийн үр ашигтайгаар ашиглах, уурхайн геологийн нөөцийн тайлан мэдээнд тулгуурлан уурхайн хүчин чадлыг тодорхойлох, техник тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийх зэрэг уурхайн үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд гол зорилго оршино. ЭБЭХ-ний сайдын 2012 оны 04-р сарын 17-ний өдрийн 074-р тушаалын дагуу ТЭЗҮ-г боловсруулах “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам”-ыг мөрдлөг болгох.
5	Ордын геологийн нөөц:	Геологи хайгуулын үр дүнгээр боловсруулагдсан нөөцийн тайланд үндэслэн тухайн уурхайг ашиглах ТЭЗҮ боловсруулан ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулна.
6	Үйлдвэрлэлийн нөөц, уурхайн хүрээ хязгаар:	Ордын нөөц, захын агуулгад үндэслэн уул уурхайн программ хангамжийг ашиглан ил уурхайн эцсийн хүрээ хязгаарыг оновчлон тогтоож, хаягдал, бохирдлын хэмжээг тооцон ордыг ашиглах үйлдвэрлэлийн үе шатны оновчлол, ашиглалт явуулах дарааллын оновчлол, симулан оновчлол, интерпрайз оновчлол зэргийг хийж хамгийн үр ашигтай хувилбарыг сонгосон байх. Уурхайн хүрээнээс гаднах нөөцийг ашиглах талаар судалгаа, оновчлол гаргах.
7	Уурхайн жилийн хүчин чадал, ашиглалтын хугацаа:	Уурхайн төмрийн хүдрийн нөөц, үйлдвэрлэл техникийн хүчин чадал, эдийн засгийн чадавхид тулгуурлан бодит байдалтай танилцаж уурхайн хүчин чадлыг тодорхойлох. Уурхайн талбарт захиалагчтай зөвшилцөнө.
9	Уурхайн төлөвлөлт:	Уурхайн ордын хэмжээнд урт, дунд хугацааны төлөвлөлт, стратеги төлөвлөгөө боловсруулж төлөвлөх, жил бүрийн уулын ахилт, төлөвлөлтөөр уурхайн хүрээг оновчлох, ил уурхайн параметрийг оновчлох. Уулын ажлын төлөвлөлтийг хөрс хуулалтын дундаж коэффициентийг жигд байхаар төлөвлөсөн байх.

10	Ашиглалтын технологи, ашиглалтын систем:	Уурхайн ашиглалтын системийн харьцуулсан тооцоо хийж үр ашигтай хувилбарыг тооцоолол судалгааны үндсэн дээр боловсруулах. Одоо хэрэгжүүлж байгаа ашиглалтын системийн оновчлол, хэрэгжилтийн үнэлэлт дүгнэлт гаргах. Ордын хэмжээнд далд уурхайн аргаар ашиглах ашиглалтын системийн судалгаа, тооцоолол боловсруулах, боломжит нөхцөл байгаа эсэхийг тодорхойлж тусгах.
11	Ажиллах горим:	Хөдөлмөрийн хуулийн холбогдох зүйл, заалтын дагуу тооцоолох. Одоо мөрдөгдөж байгаа ажлын горим хууль, дүрэмд нийцэж байгаа эсэхийг тодорхойлох.
12	Техник, тоног төхөөрөмж:	Уурхайн ашиглалтын системийн дагуу түүнд ажиллах машин механизм, хүдэр боловсруулах хуурай болон нойтон баяжуулах үйлдвэрийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хэрэгцээ, сонголтыг боловсруулах. Эдийн засгийн харьцуулалт, геологийн нөөцийг хаягдал, бохирдол багатай ашиглахад чиглэгдсэн судалгаа, тооцоолол боловсруулан сонголт хийх. Ордын чулуулгийн эзэлхүүн жин, сийрэгжилтийн судалгаа оновчлол хийх эдгээрээс хамаарсан машин механизмын ашиглалт, бүтээлийн тооцоолол хийх. Машин тоног төхөөрөмжийн үнийн санал, засвар арчилгааны талаар авсан тайлан материалыг ТЭЗҮ-д хавсаргасан байх.
13	Баяжуулалтын технологи:	Төмөртэйн уурхайд хийгдсэн технологи туршилтын тайлан, үйлдвэрийн инженерчлэл, тоног төхөөрөмжийн сонголт, боловсруулалтад үндэслэн тоо чанарын тооцоо хийх, жил бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг боловсруулах. Ордын хүдрийн баяжигдах шинж чанарт тохирсон баяжуулах аргыг сонгох, хорт хольцийг багасгах судалгаа, тоног төхөөрөмжийн сонгох, технологийн оновчлол хийх. Хаягдлын сангийн дизайн, инженерчлэл ба зардлын тооцоо тусгах.
14	Дагалдах ашигт малтмал:	Ордын хэмжээнд дагалдах ашигт малтмал, газрын ховор элементийн судалгаа, анхдагч үр дүнгийн тайланд тулгуурлан гүйцэтгэх. Төмрийн хүдэр, баяжуулах үйлдвэрийн бүтээгдэхүүнүүдэд газрын ховор элементийн шинжилгээг хийлгэж үр дүнд анализ хийж дүгнэлт, хэтийн төлөв тодорхойлох
15	Дэд бүтэц:	Уурхайн дэд бүтцийн шийдлүүд зам харилцаа, цахилгаан, ус, дулаан хангамжийн хэрэглээ, зардлуудыг тооцох. Эрчим хүчний эх үүсвэрийг үндэслэл, тооцоолол хийх. Хорголжийн үйлдвэр, Нойтон баяжуулах үйлдвэрийн эрчим хүчний эх үүсвэрийг судлаж тооцоолох. Уурхайн эдэлбэр дахь болон эдэлбэрээс гаднах байгууламжууд.
16	ХАБЭА:	Ил уурхайн аюулгүйн ажиллагааны дүрэм, тэсэлгээний аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, Уурхайд болон МУ-д мөрдөгдөж буй хууль, эрх зүйн орчны хүрээ, ХАБЭА-н ISO MNS:45001 стандартын дагуу боловсруулах. Хүний нөөц, ажиллах хүчний судалгаа
17	Байгаль орчин нөхөн сэргээлт, уурхайн хаалт:	Уурхайн байгаль орчин, нөхөн сэргээлтийн менежмент, суурь судалгаа хийх, уурхайн хаалт, хаалтын менежмент төлөвлөгөө тусгаж оруулах. ISO MNS:14001 стандартын дагуу боловсруулалт хийх.

		УУХҮЯ-ны сайд, БОАЖСайдын 2019 оны А/181, А/458 дугаартай хамтарсан тушаалын дагуу үе шатанд тусгасны дагуу хаалтын менежментийн сан байгуулах зэргийг ТЭЗҮ-д нарийвчлан тусгах.
18	Тавигдах шаардлага, тусгай нөхцөл:	Уул уурхайн технологийн зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах 5.5 заалтын дагуу ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй байх. Уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник эдийн засгийн үндэслэл хүлээн авах журмын дагуу боловсруулах. 2026 оны 2-р улирлаас Монгол ган цогцолбор 1 төслийн хүрээнд Хуурай баяжуулах үйлдвэрийг 2025 оны 4-р улирал хүртэл ажиллуулахаар төлөвлөх. 2025 оны 4-р улиралд нойтон баяжуулах үйлдвэр, хорголжийн үйлдвэр ашиглалтад оруулахаар тооцоо гаргах. Нойтон баяжуулах үйлдвэр, Хорголжийн үйлдвэрийн мэдээлэл, ажлыг тус тусад нь боловсруулж харилцан уялдааг тодорхойлж тусгах. Эрсдэл: нийгэм улс төр, санхүү эдийн засгийн эрсдэл тооцох, эрсдэлийн шинжилгээ хийх. Геотехник, гидрогеологийн судалгаа, тайланд үндэслэн уурхайн чулуулгийн тогтворжилт тооцох, дизайн инженерчлэлийн тооцоо тайлан тусгах.
19	Зах зээлийн судалгаа:	Бүтээгдэхүүний зах зээл, үнийн төлөв, худалдан борлуулах судалгааг дотоодын болон БНХАУ-ын зах зээл дэх төмрийн хүдрийн эрэлт, нийлүүлэлт, үнийн таамаглалыг дунд болон урт хугацаагаар гаргах. Дэлхийн зах зээл дээрх үнийн таамаг судалгааг урт болон дунд хугацаагаар гаргах.
20	Эдийн засаг:	Төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоог дэлгэрэнгүй тусгах, зардлуудын задаргааг дэлгэрэнгүй оруулах, бүтээгдэхүүн тус бүрээр борлуулалтын орлогыг тооцох, бүтээгдэхүүн тус бүрийн өөрийн өртгийг тооцох, эдийн засгийн мэдрэмжийн шинжилгээ, хөрөнгө оруулалт, зах зээлийн судалгаа хийх. Компанийн ашигт ажиллагаа, улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар хураамж түүний дараах зардлуудыг тооцох.
21	Мөрдөх хууль, тогтоомж, стандарт, журам, эрх зүйн баримт бичгүүд:	Ашигт малтмалын тухай хууль Газрын хэвлийн тухай хууль Байгаль орчныг хамгаалах тухай хууль Монгол Улсын Иргэний хууль Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2012 оны 074 дүгээр журам батлах тухай тушаал Бусад холбогдох журам, норм, стандартууд
22	Ажлын туршлага:	Уул уурхайн технологийн зураг төсөл, ТЭЗҮ-ийн тайлан боловсруулах, үйл ажиллагаа эрхлэх ЗТ-4.7, ЗТ-5.5 тусгай зөвшөөрөлтэй. Үйл ажиллагааны үндсэн чиглэлийн дагуу 5-аас дээш жил ТЭЗҮ-ийн боловсруулалт, тайлан гүйцэтгэж байсан, ижил төстэй 3-аас дээш ордод боловсруулалт хийж ЭБМЗ-өөр батлуулж байсан туршлагатай байх.

23	Хүний нөөц:	<ul style="list-style-type: none"> - Төслийн ахлагч – 1 /10-аас доошгүй жил уул уурхайн үйлдвэрлэл, үйл ажиллагааны чиглэлээр судалгаа шинжилгээ, зураг төсөл, ТЭЗҮ боловсруулж байсан туршлагатай байх. Уул уурхайн чиглэлээр мэргэшсэн инженер түүнээс дээш зэрэгтэй компанийн үндсэн ажилтан байх/ - МУ-ын зөвлөх инженер – 2 /20-оос доошгүй жил уул уурхайн үйлдвэрлэл, үйл ажиллагааны чиглэлээр судалгаа шинжилгээ, зураг төсөл, ТЭЗҮ боловсруулж байсан туршлагатай байх. Уул уурхайн чиглэлээр МУ-ын зөвлөх инженер зэрэгтэй байх/ - Зураг төслийн ерөнхий инженер – 1 /10-аас дээш жил тасралтгүй уурхайн зураг төсөл зохиох, төлөвлөлт судалгаа хийх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажилласан туршлагатай уул уурхайн ашиглалтын инженер мэргэжилтэй Уул уурхайн чиглэлээр МУ-ын мэргэшсэн инженер зэрэгтэй байх/ - Зураг төслийн инженер – 3 /3-аас дээш жил тасралтгүй уурхайн зураг төсөл зохиох, төлөвлөлт судалгаа хийх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажилласан туршлагатай уул уурхайн ашиглалтын инженер мэргэжилтэй байх. - Геологич инженер – 1 / 10-аас доошгүй жил хайгуул судалгаа хийх, нөөцийн тайлан тооцоо боловсруулах чиглэлээр ажилласан, зураглалын ажил дээр биет үүсгэх, агуулга тархаах зэрэг ажилбаруудыг гүйцэтгэж байсан туршлагатай байх/ - Баяжуулалтын инженер – 2 / ашигт малтмал баяжуулалт, боловсруулалтын туршилт, судалгаа, зураг төсөл, үнэлгээ, тоног төхөөрөмжийн ашиглалтын тооцоо судалгаа, үнэлгээ чиглэлээр ажиллаж байсан туршлагатай байх. Ашигт малтмалын байжуулалтын технологи мэргэжилтэй байх. - Гидрогеологич – 1 /3-аас доошгүй жил гидрогеологийн хайгуул, судалгаа, уурхайн ус шүүрүүлэлтийн чиглэлээр ажилласан байх. Гидрогеологи мэргэжилтэй байх. - Эдийн засагч – 1 /төслийн болон ТЭЗҮ-ийн хөрөнгө оруулалт, эдийн засгийн үнэлгээ, эрсдэлийн шинжилгээний чиглэлээр ажиллаж байсан туршлагатай байх. - Гадаад улсын эксперт ажиллах тохиолдолд тухайн ажилтнууд нь уул уурхайн үйлдвэрлэл, үйл ажиллагааны чиглэлээр судалгаа шинжилгээ, зураг төсөл боловсруулж байсан туршлагатай байх <p>Дээрх мэргэжилтэн, инженер, техникийн ажилчдын товч танилцуулга ирүүлэх.</p>
24	ТЭЗҮ-ийн тайлан:	<p>Гэрээ байгуулагдсанаар ажлын төлөвлөгөө, хөтөлбөр ирүүлэх, ажлын төлөвлөгөөний дагуу ТЭЗҮ-ийг боловсруулж дуусаад анхан шатны тайлан ирүүлэх, тайланд оролцогч талуудын саналыг тусгаж ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулж батлуулж эцсийн шатны тайлан ирүүлж ажиллах. Монгол хэлээр 3% бичигдсэн, зургийг DWG, PDF хэлбэрээр Micromine программ дээр суурин боловсруулалт, файл үүсгэх, бичвэр хэсгийг Word, PDF байдлаар DVD эсвэл CD дээр хуулбарласан байна.</p>

25	Дүгнэлт:	ТЭЗҮ-ийг дүгнэж төслийн үр ашиг болон хэрэгжих хугацаа, төслийн гадаад, дотоод эрсдэлүүдийг дүгнэж, зөвлөмж өгөх
----	-----------------	--


Жич: Захиалагч шаардлагатай материалыг нэмэлтээр өгч ажиллана. Гүйцэтгэгч нь ТЭЗҮ-ийг ЭБМЗ-д захиалагчийн өмнөөс хамгаалах үүрэг хүлээнэ.

ТЭЗҮ нь олон улсын банк санхүүгийн байгууллагаас санхүүжилт босгоход хүлээн зөвшөөрөгдөхүйц чанарын түвшинд боловсруулагдсан байна. ТЭЗҮ-ийг боловсруулж, ЭБМЗ-өөр батлуулах хугацаа нь гэрээ байгуулснаас хойш 60 хоногоос хэтрэхгүй байна.

Гүйцэтгэгч тал ТЭЗҮ боловсруулах, ТЭЗҮ-ийг ЭБМЗ-д танилцуулж хамгаалах, ТЭЗҮ-ийг ЭБМЗ-өөр батлуулах, уурхайн талбарт томилолтоор ирж ажиллах зардал, гадаад улсын экспертүүдтэй хамтран ажилласан тохиолдолд тухайн ажилд гарсан зардлыг хариуцна.

Хянасан:

ГУУХ-н дарга



Г.Хишигбаяр

Техникийн даалгавар боловсруулсан:

ГУУХ-н ашиглалтын ахлах инженер



Н.Мижидсамдан

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч ТӨХ-д тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна ТШЗ-ны 34.1.6-д заасан нэг буюу хэд хэдэн хүчин зүйлийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр бусад аливаа шалгуур үзүүлэлт, аргачлалыг үнэлгээнд харгалзахгүй.

1. Ажил гүйцэтгэх хуваарь: [“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих**]**

Хэрэв “ашиглах” бол: Тухайн тендер шалгаруулалтад холбогдох гэрээний дагуу үе шатны ажлын хуваарьт заасан зөвшөөрөгдөх хугацааны хооронд (ажил гүйцэтгэж эхлэх хамгийн эхний өдрөөс хойш ажил гүйцэтгэж дуусах хамгийн сүүлчийн өдрийг оролцуулан) гүйцэтгэх шаардлагатай. Үе шатны ажлын хуваарьт заасан хугацаанаас өмнө гүйцэтгэх санал ирүүлсэн тендерт урамшуулал буюу үнэлгээнд бусад тендерээс давуу нөхцөл байдал олгохгүй.

*Захиалагч уг шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд ашиглахаар тусгайлан зөвшөөрсөн тохиолдолд үе шатны ажлын хуваарьт зааснаас хоцорч нийлүүлэхээр санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор хоцорсон хоног тутамд [**хувь бичих**]-иар тооцож тендерийн үнэ дээр нэмнэ.*

*Ажлыг үе шатны ажлын хуваарьт зааснаас [**тоо бичих**]-аас илүү [**“сар”, “өдөр” гэдэг үгнээс сонгож бичих**] хоцроож гүйцэтгэхээр санал болгосон тендерээс татгалзана. Харин ТӨХ-д тусгайлан зөвшөөрөөгүй тохиолдолд захиалагчийн тогтоосон хугацаанаас хойш гүйцэтгэхээр санал болгосон тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзнэ.*

2. Тендерт санал болгосон ажил болон болон тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах бараа нийлүүлэх тендер шалгаруулалтын үед шаардагдах урсгал зардал, үйл ажиллагааны баталгаа болон үр ашигтай байдал: [“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих**]**

*Хэрэв “ашиглах” бол тендерт санал болгосон ажлын [**тоо бичих**] [**“сар”, “өдөр”, “жил” гэдэг үгнээс сонгож бичих**] хугацаанд шаардагдах урсгал зардлын хэмжээг тооцоолж ашиглалтын нийт хугацаанд шаардагдах нэмэлт зардлын дүнг үнэлгээний зорилгоор тендерийн нийт үнэ дээр нэмж үнэлнэ.*

Мөн тендерийн дагуу санал болгосон ажлын үр ашгийн байдлыг үнэлгээний зорилгоор тендерийн нийт үнэ дээр нэмж үнэлж болно.

3. Тендерт санал болгосон ажлыг хүлээлгэж өгсөний дараах үйлчилгээг үзүүлэх боломж: [“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих.]

Хэрэв “ашиглах” бол урсгал засвар хийх болон үндсэн/шаардлагатай бараа материалаар хангахын тулд захиалагчид шаардагдах зардлыг тусад нь үнэлж ирүүлсэн бол түүнийг үнэлгээний зорилгоор тендерийн нийт үнэ дээр нэмж үнэлнэ.

4. Тусгайлсан нэмэлт шалгуур

Хуулийн 28.4 дэх хэсэгт заасныг үндэслэн энэхүү тендерийн үнэлгээнд ашиглах нэмэлт шалгуур үзүүлэлт болон түүний аргачлалыг энэ хэсэгт оруулж болно.

[Тухайлбал, эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн ажил гүйцэтгэх тендерийн харьцуулах үнийг хэрхэн тодорхойлох шалгуур үзүүлэлтийг энд бич.

Тогтвортой худалдан авах ажиллагааны шалгуур үзүүлэлтийн талаар Төрийн тогтвортой худалдан авах ажиллагааны гарын авлага (МУСЯ, НҮББОХ, 2018)-аас танилцах боломжтой.]

V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТУУД

Маягт 1	Тендер илгээх маягт	1
Маягт 2	Тендерийн баталгаа (банкны)	2
Маягт 3	Тендерийн баталгаа (Засгийн газрын бондын болон Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаас)	3
Маягт 4	Тендерт санал болгож байгаа хүний нөөцийн мэдээлэл	5
Маягт 5 ..	Тендерт санал болгож байгаа үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл	5
Маягт 6	Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл	5
Маягт 7	Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл	6
Маягт 8	Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл	6

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай **[тендерт оролцогчийн нэр]** нь танай байгууллагаас зарласан **[тендер шалгаруулалтын нэр, дугаар]** тендер шалгаруулалтад **[үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу ажил гүйцэтгэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “**тендер**” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээний маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүнтэй холбоотойгоор тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 16.1-д заасан нөхцөл байдал үүсээгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт **[“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бич]. [Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих].**
5. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш **[30 ба түүнээс дээш хоногийн тоо]** хоногийн хугацаанд хүчинтэй байна.²
6. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 12.4 болон 16.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон ажил болон тухайн ажлыг гүйцэтгэхтэй холбоотой бараа, үйлчилгээ нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,

эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,

албан тушаал, гарын үсэг,

байгууллагын тамга, тэмдэг]:

Хаяг:

² Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол “5. Тендер нь тендерийн баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.” гэж сольж бичнэ үү.

Маягт 2 Тендерийн баталгаа (банкны)

Баталгаа хүлээн авагч: **[захиалагч байгууллагын нэр, хаягийг бичих]**

Огноо: **[баталгаа гаргасан огноог бичих]**

Дугаар: **[тендерийн баталгааны дугаар бичих]**

Баталгаа гаргагч: **[хэвлэмэл хуудсанд бичигдээгүй бол баталгаа гаргагч банкны нэр, хаягийг бичих]**

1. Баталгаа гаргагч нь **[тендерт оролцогчийн нэр]** (цаашид “тендерт оролцогч” гэх)-аас **[тендер шалгаруулалтын нэр, дугаар]** тендер шалгаруулалтад оролцож тендер (цаашид “тендер” гэх) хүргүүлэхтэй холбогдуулан баталгаа хүлээн авагчийн өмнө нийт **[мөнгөн дүн]**-ийн³ төлбөрийн үүрэг хүлээх баталгаа гаргаж байна.
2. Энэхүү баталгааны дагуу төлбөр төлөх үүрэг дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:
 - 2.1. Тендер нээсний дараа, тендерийн хүчинтэй байх хугацаа (сунгасан хугацааг оролцуулан цаашид “Тендер хүчинтэй байх хугацаа” гэх) дуусахаас өмнө тендерт оролцогч тухайн тендерээс бүхэлд нь эсхүл хэсэгчлэн татгалзсаныг бичгээр мэдэгдсэн;
 - 2.2. Тендерт оролцогч гэрээ байгуулах эрх авсан үед тендерийн баримт бичигт заасны дагуу:
 - 2.2.1. ТШЗ-ны 40 дүгээр зүйлд заасны дагуу гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулаагүй;
 - 2.2.2. гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй;
 - 2.2.3. тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй, эсхүл зөвшөөрсөн эсэх тухай хариуг бичгээр ирүүлээгүй.
 - 2.3. Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендерт оролцогчийн гаргасан гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.
3. Дээр тодорхойлсон аль нэг нөхцөл үүссэнийг дурдаж төлбөр төлүүлэх тухай захиалагчийн анхны шаардлагыг хүлээн авсан даруйд баталгаа гаргагч төлбөрийг тус мэдэгдэлд заасан Монгол Улсын Сангийн яамны дансанд шилжүүлнэ. Баталгаа гаргагчаас төлөх шаардлагын хэмжээ нь 1-д заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба 2.3-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд 20 сая хүртэл төгрөг эсхүл түүнтэй тэнцэх гадаад валютаас хэтрэхгүй байна.
4. Энэхүү баталгаа Тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна. Баталгаа гаргагч энэ хугацаанаас өмнө гэрээ байгуулсан тухай мэдэгдлийг хүлээн авсан тохиолдолд баталгааг хугацаанаас өмнө хүчингүй болгож болно.
5. Энэхүү баталгааны дагуу гаргах аливаа шаардлагыг баталгааны хүчинтэй хугацаанд багтааж баталгаа гаргагчид мэдэгдэнэ.
6. Энэхүү баталгааг дээр дурдсанаас бусад үндэслэлээр хүчингүй болгосонтой холбоотой хариуцлагыг баталгаа гаргагч хүлээнэ.

[Баталгаа гаргагч нь гадаадын этгээд бол тендерийн баталгааны дагуу хүргүүлэх шаардлагыг баталгаа гаргагчийн нэрийн өмнөөс хүлээн авах Монгол Улсад үүсгэн байгуулагдсан банк, санхүүгийн байгууллага, бусад этгээдийг заана уу.]

[Банкны эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]

³ Энэ дүн нь ТШЗ-ны 22.1-д заасантай ижил байна.

Маягт 3 Тендерийн баталгаа (Засгийн газрын бондын болон Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаас)

Баталгаа хүлээн авагч: **[захиалагч байгууллагын нэр, хаягийг бичих]**

Огноо: **[баталгаа гаргасан огноог бичих]**

Дугаар: **[тендерийн баталгааны дугаар бичих]**

Баталгаа гаргагч: **[хэвлэмэл хуудсанд бичигдээгүй бол баталгаа гаргагч банкны нэр, хаягийг бичих]**

1. Баталгаа гаргагч нь **[тендерт оролцогчийн нэр]** (цаашид “тендерт оролцогч” гэх)-ийг **[тендер шалгаруулалтын нэр, дугаар]** тендер шалгаруулалтад оролцож тендер (цаашид “тендер” гэх) хүргүүлэхтэй холбогдуулан баталгаа хүлээн авагчийн өмнө нийт **[мөнгөн дүн]**⁴ төгрөг буюу түүнтэй тэнцэх гадаад валютын төлбөрийн үүрэг хүлээх баталгааг нийт **[мөнгөн дүн]** төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий **[Засгийн газрын бонд эсхүл үнэт цаасны нэр болон холбогдох бусад мэдээллийг бичих]** (цаашид “Үнэт цаас” гэх)-г⁵ үндэслэн гаргаж байна.
2. Энэхүү баталгааны дагуу Үнэт цаасыг шилжүүлэх үүрэг нь дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:
 - 2.1. Тендер нээсний дараа, тендерийн хүчинтэй байх хугацаа (сунгасан хугацааг оролцуулан цаашид “Тендер хүчинтэй байх хугацаа” гэх) дуусахаас өмнө тендерт оролцогч тухайн тендерээс бүхэлд нь эсхүл хэсэгчлэн татгалзсаныг бичгээр мэдэгдсэн;
 - 2.2. Тендерт оролцогч гэрээ байгуулах эрх авсан үед тендерийн баримт бичигт заасны дагуу:
 - 2.2.1. гэрээг баталгаажуулж ирүүлээгүй;
 - 2.2.2. гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй;
 - 2.2.3. тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй, эсхүл хүлээн зөвшөөрсөн эсэх тухай хариуг бичгээр ирүүлээгүй.
 - 2.3. Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендерт оролцогчийн гаргасан гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.
3. Дээр тодорхойлсон аль нэг нөхцөл үүссэнийг дурдаж Үнэт цаасыг шилжүүлэх тухай захиалагчийн анхны шаардлагыг хүлээн авсан даруйд баталгаа гаргагч Үнэт цаасыг Монгол Улсын Сангийн яамны нэр дээр шилжүүлнэ. Баталгаа гаргагчаас шилжүүлэх Үнэт цаасны нэрлэсэн үнийн дүн нь 1-д заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба 2.3-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд 20 сая хүртэл төгрөг эсхүл түүнтэй тэнцэх гадаад валютаас хэтрэхгүй байна.
4. Энэхүү баталгаа Тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна. Баталгаа гаргагч энэ хугацаанаас өмнө гэрээ байгуулсан тухай мэдэгдлийг хүлээн авсан тохиолдолд баталгааг хугацаанаас өмнө хүчингүй болгож болно.
5. Энэхүү баталгааны дагуу гаргах аливаа шаардлагыг баталгааны хүчинтэй хугацаанд багтааж баталгаа гаргагчид мэдэгдэнэ.
6. Энэхүү баталгааг дээр дурдсанаас бусад үндэслэлээр хүчингүй болгосонтой холбоотой хариуцлагыг баталгаа гаргагч хүлээнэ.

